



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 4/118

Ховд

158

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Шинэ сэргэлтийн бодлогын 6.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/05 дугаар тогтоолоор баталсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үүлэн технологид суурилсан (офис 365) системийн 18 хэрэглэгч дээр лицензийг нэмж худалдан авах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Н.Ганзориг (Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд:

Б.Батнасан (Санхүү, төрийн сангийн
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Ц.Оюунчимэг (Хяналт-шинжилгээ, үнэлгээний
хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Дөмөгтүшиг (Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн
дарга:

Н.Цэрмаа (Төрийн захиргааны удирдлагын
хэлтсийн мэргэжилтэн)

2. Ажлын хэсгийн гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, сонгон шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Н.Ганзориг)-д үүрэг болгосугай.

3. Дээрх сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгч үүсгэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга (Н.Цэрмаа)-д үүрэг болгосугай.

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРСҮХ

